



**“ТРАНС-АЗИЙН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурал “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2007 оны 10 сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

Транс-Азийн төмөр замын сүлжээнд улс хоорондын төмөр замын тээвэртэй холбоотой зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг цаашид уялдуулах үндэс суурийг бий болгох зорилгоор Тайланд Улсын Бангкок хотноо 2023 оны 09 дугээр сарын 14, 15-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдсан Транс-Азийн төмөр замын сүлжээний ажлын хэсгийн 8 дахь удаагийн хуралдаанаар Исламын Бүгд Найрамдах Иран Улсын санаачилсан хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг олонхын саналаар баталсан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана” гэж заасны дагуу “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай.

Практик шаардлага

Монгол Улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (НҮБ-ын АНДЭЗНК)-ын гишүүн орны хувьд тус байгууллагаас баталсан бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ, конвенц, протоколд нэгдэх, бус нутагт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны хөтөлбөр, төсөл, уулзалт, семинар, хурал чуулган, сургалтад хамрагдах зэргээр “оролцогч” улсын байр суурийг хадгалж, олон улсын төмөр замын тээврийн үйл хэрэгт оролцож байна.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн баталсан нэмэлт, өөрчлөлтийг Талуудын гуравны хоёр нь хүлээн авснаас хойш арван хоёр (12) сарын дараа хүчин төгөлдөр болох зохицуулалттай. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын нарийн бичгийн дарга

нарын газраас ирүүлсэн албан бичигт 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар талуудаас ямар нэгэн санал, эсэргүүцэл ирүүлээгүй тухай дурдсан.

Хэлэлцээрт "Транс-Азийн төмөр замын сүлжээний хүрээнд төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох тухай ерөнхий зарчмууд" шинэ гуравдугаар хавсралтыг нэмсэн бөгөөд Транс-Азийн төмөр замын сүлжээнд улс хоорондын төмөр замын тээвэртэй холбоотой зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хилийн хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг цаашид уялдуулах үндэс суурийг бий болгосон.

Монгол Улсын төмөр замын тээврийн харилцаа өргөжин хөгжиж, тээврийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй энэ үед төмөр замын тээврийг цахимжуулах эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн практикт нийцүүлэх, уялдуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байгаа болно.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд "Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн нэмэлт өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа сөрөг үр дагавар үзүүлэхгүй, улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Мөн төмөр замууд хооронд, түүнчлэн төмөр замууд болон хяналтын байгууллагууд хооронд харилцан цахим мэдээлэл/өгөгдөл солилцох үйл ажиллагааг талуудын хүлээн зөвшөөрсөн зарчмаар зохицуулах нь бус нутгийн хэмжээнд хэлэлцээр байгуулах эрх зүйн үндэстэй болох, улмаар хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж, цаг хугацаа, зардлыг бууруулах, олон улсын төмөр замын тээврийн найдвартай байдал, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

---оОо---